



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/508

Мандалговь

2018 онд гаргах уст цэгийн нэр,
Байшилд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.6, аймгийн нийгэм эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 4.1.2 дах заалт, гүн өрмийн машин, тоног, төхөөрөмж түрээслэгч Элбэг санчир ХХК-тай 2018 онд байгуулсан гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А/224 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтад заасан Дэрэн сумын нутагт орших "Эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл" ОНӨҮГ-т гүн өрмийн худаг гаргах байсан боловч цэг тогтоогдоогүйн улмаас гаргах боломжгүй болсон тул Дэрэн сумын Алаг-Өндөр багийн "Чихэрт" гэдэг газарт болгон шилжүүлэн өөрчилсүгэй.

Хоёр. Шилжүүлэн өөрчилсөн худгийг сум, багийн засаг даргад танилцуулан чанартай бүрэн гүйцэд хийж, гүйцэтгэн ажлын хэсэгт хүлээлгэн өгөхийг "Элбэг санчир" ХХК (О.Хүүхэнбаатар)-т, худгийн ашиглалт, хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Н.Мядагмаа)-д тус тус даалгасугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т, Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010568